



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/630

Есөнбулаг

Сумдын Засаг даргын Тамгын
газрын бүтэц, орон тооны жишиг
хязгаарыг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын орон тоог 22, Баян-Уул, Дэлгэр, Цогт сумдын Засаг даргын Тамгын газрын орон тоог 18, Тайшир, Алтай, Бигэр, Бугат, Дарив, Жаргалан, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ сумдын Засаг даргын Тамгын газрын орон тоог 16 орон тоотойгоор тогтоосугай.

2. Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын жишиг орон тоог нэгдүгээр хавсралтаар, Баян-Уул, Дэлгэр, Цогт сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын жишиг орон тоог хоёрдугаар хавсралтаар, Тайшир, Алтай, Бигэр, Бугат, Дарив, Жаргалан, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын жишиг орон тоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Батлагдсан орон тоонд багтаан сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, цалингийн санг шинэчлэн тогтоож, төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах замаар хуулийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Сумын эдийн засаг, нийгмийн хөгжил, дэд бүтцийн бодлого, зохицуулалт, төлөвлөлт, болон онцгой байдал, цаг үеийн бусад ажлыг зохион байгуулах чиг үүргийг баталж, сумын Засаг даргын орлогчид хариуцуулан ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/630 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР

C:\Documents\ ZD A-4 doc

0202001417

Аймгийн Засаг даргын 2023 оны 12
дугаар сарын 17 ны өдрийн 10 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЦОГТ, БАЯН-УУЛ, ДЭЛГЭР СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЖИШИГ ОРОН ТОО

д/д	Албан тушаал	Орон тоо
1	Тамгын газрын дарга	1
2	Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	1
3	Санхүүгийн албаны дарга	1
4	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
5	Хөдөө аж ахуйн тасгийн дарга	1
6	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
7	Бэлчээр, тэжээл, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
8	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн (Улсын байцаагчийн эрхтэй)	1
9	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн	1
10	Хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн	1
11	Мэдээллийн технологи, олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1
12	Нягтлан бодогч	1
13	Тохижилт, ногоон байгууламж хариуцсан ажилтан	1
14	Нийтийн биеийн тамир, эрүүл мэндийн ажил хариуцсан аргазүйч	1
15	Архив, бичиг хэргийн ажилтан	1
16	Нярав	1
17	Жолооч	1
18	Үйлчлэгч	1
Гэрээг ажилтан		
19	Цэвэрлэх байгууламжийн ажилтан	2
20	Бусад	-

__оОо__

Аймгийн Засаг даргын 20²³ оны 12
дугаар сарын 11-ны өдрийн 1672 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ТАЙШИР, АЛТАЙ, БИГЭР, БУГАТ, ДАРИВ, ЖАРГАЛАН, ТОНХИЛ, ТӨГРӨГ,
ХАЛИУН, ХӨХМОРЬТ, ЦЭЭЛ, ЧАНДМАНЬ, ШАРГА, ЭРДЭНЭ СУМДЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЖИШИГ ОРОН ТОО

д/д	Албан тушаал	Орон тоо
1	Тамгын газрын дарга	1
2	Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	1
3	Санхүүгийн албаны дарга	1
4	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
5	Хөдөө аж ахуйн тасгийн дарга	1
6	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
7	Бэлчээр, гэжээл, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
8	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн (Улсын байцаагчийн эрхтэй)	1
9	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн	1
10	Хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн	1
11	Мэдээллийн технологи, олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1
12	Нягтлан бодогч	1
13	Тохижилт, ногоон байгууламж хариуцсан ажилтан	1
14	Нийтийн биеийн тамир, эрүүл мэндийн ажил хариуцсан аргазүйч	1
15	Архив, бичиг хэргийн ажилтан	1
16	Нярав	1
Гэрээт ажилчин		
1	Жолооч	1
2	Үйлчлэгч	1
3	Цэвэрлэх байгууламжийн ажилтан	2
4	Бусад	-

__ооо__

